

ХӨТӨЛБӨРИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 01 дүгээр сарын 22

№04

Улаанбаатар хот

Хөтөлбөрийн ерөнхий хорооны хурал 2026 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр 10:00 цагаас 85,7 хувийн ирцтэй эхэлж, ХЕХ-ны дарга Н.Эрдэнэхүү удирдан явуулав.

Хуралд:

Хөтөлбөрийн ерөнхий хорооны дарга

1. Н.Эрдэнэхүү Сургалт, оюутны асуудал эрхэлсэн проректор

Нарийн бичгийн дарга

2. М.Эрдэнэтуяа Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга

Гишүүд

3. И.Цэрэн-Онолт АТС-ийн захирлын үүрэг гүйцэтгэгч
4. Б.Майзул ХХҮДС-ийн биотехнологи, шим судлалын тэнхимийн профессор
5. Ц.Цэцэгмаа ГХС-ийн хэрэглээний хэл шинжлэлийн тэнхимийн профессор
6. Д.Ариунболор НБХ-ийн профессор
7. Ц.Балжинням ХШУС-ийн сургалт, чанарын албаны дарга
8. П.Ууганбаяр МХТС-ийн сургалт, чанарын албаны дарга
9. И.Базаррагчаа МИТС-ийн тээвэр, логикийн тэнхимийн эрхлэгч
10. Ш.Цоож МИТС-ийн механик инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
11. Я.Наранцэцэг АТС-ийн профессор
12. Ц.Энхбаатар ГХС-ийн захирал
13. Ч.Алдармаа ХШУС-ийн физикийн тэнхимийн профессор (ӨмТДС-ийн төлөөлөл, зөвшилцсөнөөр)
14. Д.Үлэмж ЭХИС-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга
15. С.Туяа НХС-ийн сургалт, чанарын албаны дарга
16. Ж.Алтанцэцэг БАС-ийн барилгын инженерчлэлийн тэнхимийн дэд профессор
17. М.Банзрагч МС-ийн сургалт, чанарын албаны дарга
18. Г.Ариунтөгс Сургалтын бодлого, зохицуулалтын албаны ахлах мэргэжилтэн

нар оролцов.

Хэлэлцэх асуудлууд:

1. “Нано шинжлэх ухаан, инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Шанхайн зам тээврийн сургуультай (2+2) хамтарсан хөтөлбөр нээх тухай (ХШУС)
2. “Материал судлал, инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Шанхайн зам тээврийн сургуультай (2+2) хамтарсан хөтөлбөр нээх тухай (ХШУС)
3. “Нүүрсний боловсруулалтын технологи” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Уул уурхай технологийн их сургуультай (2+2) хамтарсан хөтөлбөр нээх тухай (ХШУС)
4. Бусад асуудал

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. ХШУС-д “Нано шинжлэх ухаан, инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Шанхайн Зам тээврийн их сургуультай хамтарсан (2+2) хөтөлбөр (англи хэл) нээх тухай асуудлыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн, хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
2. ХШУС-д “Материал судлал, инженерчлэл” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Шанхайн Зам тээврийн их сургуультай хамтарсан (2+2) хөтөлбөр (англи хэл) нээх тухай асуудлыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн, хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
3. ХШУС-д “Нүүрсний боловсруулалтын технологи” бакалаврын хөтөлбөрөөр БНХАУ-ын Уул уурхай технологийн их сургуультай хамтарсан (2+2) хөтөлбөр нээх тухай асуудлыг хөтөлбөрийн ерөнхий хорооны гишүүдийн зөвлөмжийн дагуу зарим бүрэлдэхүүн хэсэгт сайжруулалтыг хийн, хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, хэрэгжүүлэхийг гишүүдийн 100 хувийн саналаар дэмжлээ.
4. Хөтөлбөрийн ерөнхий хорооны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан дараах ажлуудын хэрэгжилтийг хангах хүрээнд төсөл, санал боловсруулж, хөтөлбөрийн ерөнхий хороонд хэлэлцүүлж, шийдвэрлүүлэхийг гишүүдэд үүрэг болгов. Үүнд:
 - ШУТИС-ийн хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын төслийг боловсруулахыг М.Банзрагч, П.Ууганбаяр нарт;
 - Хөтөлбөрийн төгсөгчид олгох мэргэжлийн зэргийг шинэчлэх санал боловсруулахыг Б.Майзул, С.Туяа нарт;
 - Сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх аргачлал боловсруулахыг Д.Ариунболор, Ч.Алдармаа нарт;
 - Сургалтын хөтөлбөрийн харьяалал тогтоох санал боловсруулахыг Г.Өлзийсайхан, Д.Болор-Эрдэнэ, Н.Одонтуяа нарт;